

# Тахийн Мэдээ

№ 18 / 2022 оны 12-р сар

## Өв залгамжлалыг үргэлжлүүлбэ



Ө. Анар



Есүй, Нийслэлийн 111-р сургууль



С.Сүххуяг



Х.Ууданцайзэг



Ч.Чингүүн, Төв аймаг, Аргалант ахлах сургууль



Х.Сувд, Хөвсгөл аймаг



Т.Туулайхүү, Говь-Алтай аймаг, Тонхил сумын ЕБС



Э.Түмбаяр, Говь-Алтай аймаг, Тонхил сумын ЕБС



Г.Номиндэлгэр, Нийслэлийн 5-р сургууль



Г.Хасбаатар, Нийслэлийн 14-р сургууль




С.Хонгорзул, Нийслэлийн 73-р сургууль



Л.Хөлгөнсүдар



Н.Баттөр, Төв аймаг, Аргалант ахлах сургууль



А.Ганзаяа, Говь-Алтай аймаг, Тонхил сумын ЕБС



Б.Энхзүл, Нийслэлийн 74-р сургууль

Адууны өвөг болох тахийг амьдрах орчинд нь хамгаалцгаая.

## Зэрлэг адууны хүндэт анд найз нараа,



Бидний ихэнх нь толгой эргэм хурдацтай өөрчлөгдөж буй хүний ертөнцтэй тулгарч улам бүр тулгамдаж байна. Арван жил тутам бид техникийн хувьслын цоо шинэ нээлтүүдтэй тулгарч байдаг. Үүний үр дагаварыг урьдчилан таамаглах аргагүй бөгөөд дагаж мөрдөхөд ч төвөгтэй байдаг билээ. Энэ нь

зөвхөн бидэнд ч хамааралтай биш. Амьдралын эмзэгхэн болсон сүлжээнүүд ч бас энэ ачаалалд нэрвэгдэж байгаа. Байгалийн хувьсал нь олон мянган жилээр хэмжигддэг удаан хугацааны үйл явц байдаг. Энэхүү хувьсалын хэрэгсэл нь геном бөгөөд, түүний оршин тогтнолын үр дүн нь сөрөг нөхцөл байдал, олон талт өрсөлдөөнд төгсгөлгүй мэт санагдах үе удмаа хадгалах явдал юм. Тэдний геном бол эдгээр олон мянган жилийн амьдралын туршлагын тэмдэглэл бөгөөд энэ нь хиймэл бус харин байгалийн оюун ухаан болно. Төрөл зүйл устах нь амьдрах чадварын мянган боть зааварчилгааг шатаахтай адил юм. Учир нь тэдний геном бол эдгээр олон мянган жилийн амьдралын туршлагын тэмдэглэл юм.

Тахь бол бүрэн устахаас амь мөлтөс мултарсан. Одоо сэргээн нутагшуулсан тахийн үлдэгдэл сүргийг амьдрах орчныг нь хэтрүүлэн ашиглах, халдварт өвчин, аюултай эрс тэс цаг агаар, гэрийн адуутай цус холилдох зэрэг гол аюул заналаас хамгаалах ёстой. Үүнд хүрэх нь бидний эрхэм зорилго юм.

Гэхдээ Говийн Их дархан цаазат газар (ГИДЦГ)-ын “Б” хэсгийн орчны бүсийн нутгийн иргэд энэхүү зорилгыг дэмжиж байгаа нь амжилтад хүрэх хамгийн чухал зүйл билээ. Мэдээж тэд ДЦГ-ын нутагт өөрсдийн ашиг сонирхолыг эрхэмлэх нь ойлгомжтой. Иймээс, орон нутгийн иргэдийн сайн сайхны төлөөх үйл ажиллагаа нь бидний хоёрдогч зорилго байх болно. Хэдийгээр, бэлчээрийн ашиглалтыг зохистой байлгах нь хэцүү ч малчид, байгаль хамгаалагчдын хувьд энэ нь үр өгөөжтэй. Бид хамтдаа мал аж ахуйгаас гарах нэмүү өртгийг нэмэгдүүлж, аялал жуулчлалын болон бусад арилжааны боломжуудыг хөгжүүлэхийг хүсэж байна. Мөн өсвөр үеийнхэнд бүх амьд орчныг дээдлэх, зэрлэг байгаль, ургамал, амьтдыг сонирхох сэтгэлгээг хөгжүүлэх нь бидний хувьд чухал юм. 2022 онд бидний зохион байгуулсан Залуу судлаачдын семинарт монгол залуус энэ сэдэвт дүгнэн шинжлэх ухаанч байдлаар хандахыг хичээж, улмаар тахийн сэдэвтэй зургийн уралдаанд идэвхтэй оролцлоо. Тахийн мэдээний эхний хуудсанд бүтээлүүдийн дээжээс толилуулсан билээ.

Бидний энэ хурдацтай хөгжиж буй цаг үед энэхүү нандин өвийг аврахын тулд хангалттай орон зай өгөх нь чухал гэдгийг улам олон хүмүүс ойлгож байна. Энэ хүчин чармайлтад Та бүгд бидэнтэй хамт байгаад талархаж байна! Тан бүгдийн үнэнч дэмжлэггүйгээр бид энэ их зүйлийг хийж чадахгүй. Та бүхний цаашдын дэмжлэгт найдаж байна.

Жич: Тахийн эх нутгийг Та өөрийн биеэр үзмээр байна уу? ГИДЦГ-ын “Б” хэсэг дахь зэрлэг адуутай танилцах сонирхолтой адал явдалт аялал Таныг хүлээж байна!

Та зориглож аялах уу?

Др. Райнхард Шнидрих, Олон Улсын Тахь Группийн Ерөнхийлөгч

“Монгол дахь ОУТГ-ийн захирал Жамъяндоржийн Батсүх долоо хоногийн хугацаатай явагдсан “Залуу судлаачид-2022” хөтөлбөрийн нээлтэнд оролцогчидод мэндчилгээ дэвшүүлж байгаа нь.



Гэрэл зургийг Ч.Пунсал, Норовлин сургууль

“Бид өсвөр үеийнхэнд зэрлэг байгаль, ургамал, амьтдыг сонирхох, дээдлэх сэтгэлийг төлөвшүүлэх нь чухал юм.”

## ДЦГ-ын туурайтан амьтдын популяцийн тооллого

Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн төрөл зүйлийг хамгаалах ажлын үр дүнг хэмжих хамгийн чухал шалгууруудын нэг болох туурайтан амьтдын популяцийн тооны өсөлт ба түүнийг тодорхой давтамжтай тоолох явдал юм. Энэхүү тооллогыг 2020, 2021 онуудад Коронавирусын цар тахлын улмаас хойшлуулсан билээ. 2022 оны 8-р сард та бүгдийн хандивын дэмжлэгтэйгээр тооллогын ажлыг хийх боломжтой болсон. Өндөр хүчин чадалтай дрон ашиглах төлөвлөгөөтэй байсан боловч гаалийн бүрдүүлэлтийн ажлаас хамааран 2023 онд хийгдэхээр төлөвлөгөөд явж байна.

Тооллогын үр дүн хараахан гараагүй байгаа ба энэ нь Инланд Норвегийн хэрэглээний шинжлэх ухааны их сургуулийн докторын зэрэг горилогч Томас Фоглер оюутан гүйцэтгэж байгаа болно. Тооллогын эхний үр дүнгээс харахад хар сүүлт зээрийн тоо толгой нэмэгдэж, энэ жил олон ихэр төл авснаар сайн үржсэн дүн гарсан. Хулангийн тоо толгой тогтвортой байгаа бөгөөд унаганы тоо ердийнхөөс арай бага байх магадлалтай. Гэвч энэ жил ган ихтэй байсан тул цөөн хэдэн газарт хулан ихээр төвлөрч, популяцийн нарийвчилсан тоог гаргахад хүндрэлтэй байсан. Өдөр дутмын тахийн мониторингийн сүргийн нарийвчилсан мэдээлэл болон цэгэн тооллогын ажиглалтын цэг зэргээс тахийн тоо нэмэгдэж байгаа харагдаж байна. Цэгэн тооллогын урьдчилсан дүгнэлтээр ДЦГ-ын туурайтан амьтдын популяцийн өссөн байна!

*Тус Дархан цаазат газарт тал хээрийн туурайтан амьтны нөөц хэрхэн өсөн үржиж байна вэ? Бид таван жил тутам “Талын туурайтан амьтны цэгэн тооллого” зохион байгуулж энэ асуултанд хариулахыг хичээдэг. Тооллого хийхдээ 102 ажиглалтын цэгийг тодорхойлж хэд хоногийн турш зэрэг тоолж, тооллогын үр дүнг нэгтгэснээр ДЦГ-ын нийт талбай дахь мэдээ гардаг. Энэ нь нийтдээ 18'000 км2 талбайг хамардаг буюу Швейцар Улсын нутгийн бараг тал хувьтай тэнцүү талбай гэсэн үг. Өргөн уудам газар нутагт тооллогыг явуулахад хүн хүч ихээр шаардагддаг тул бидэнд олон талын бэрхшээл тулгарсаар байна. Тиймээс, ялангуяа том сүрэг амьтдыг агаараас илүү нарийвчлалтай тоолох боломжтой тул бид хагас мэргэжлийн дрон (нислэгийн хугацаа 3 цагаас илүү) -ыг туршиж үзэх нь гарцаагүй шаардлагатай гэж үзэж байна.*

*Зураг дээр: Олон Улсын тахь группийн биологич Г.Ёндон, ГИДЦГ-ын “Б” хэсгийн Хамгаалалтын захиргааны ахлах мэргэжилтэн Н.Алтансүх нар ДЦГ-ын газрын зургийн өмнө; болон ажиглалтын цэгт, сэрүүн шөнө унтахад бэлтгэсэн байдал. Зургийг: ©Петра Каченски*



Б.Дэвамаа, 2-р сургууль



Б.Мөнх-Амар, 45-р сургууль

Коронагийн цар тахлын улмаас хоёр ч удаа хойшилсны дараа бид 2022 онд туурайтан амьтдын цэгэн тооллогыг гүйцээн хийж чадсан.

## 70 унага хатуу өвлийг хэрхэн давах вэ?

Эхлээд сайн мэдээг танилцуулъя: Зэрлэг адуу (Тахь) удамшлын үнэт өвөө хадгалан үлдэхийн тулд чадах бүхнээ хийж байна! Говийн Их дархан цаазат газрын "Б" хэсэг дахь тахийн тоо толгой өсөхийн хэрээр жил бүрийн унага төллөлт нэмэгдэж байна. Энэ жил 349 тахийн тоо толгой 70-аас доошгүй төлөөр нэмэгдсэн байна. Энэ нь маш таатай мэдээ.

Гэсэн хэдий ч сүргийн тоо нэмэгдэхийн хэрээр унаганы хорогдол нэмэгджээ. Төрсний дараа эхний жилдээ залуу бодгаль нь цаг агаарын нөхцөл байдал, өвчин, махчин амьтанд (чоно) маш өртөмтгий байдаг. Сүүлийн 10 жилд хийсэн судалгаагаар, унаганы 30-40 хувь нь эхний жилдээ хорогдсон байна.

Тахийн хувьд цаг агаарын эрс тэс уур амьсгал, халдварт өвчин онцгой аюултай бөгөөд нэг дор олон тооны тахь хорогдсоноор цөөн тоотой популяцид аюул учруулж болзошгүй юм. Үнэн хэрэгтээ гантай зуны дараа аймшигт "Зуд" буюу хахир хүйтэн өвөл болдог. Сульдсан, хоол тэжээлийн дутагдалд орсон амьтад хүнд өвлийг тэсвэрлэх чадвар багатай байдаг тул бид үүнд санаа зовниж байна.

Дархан цаазат газрын удирдлагууд урьдчилан сэргийлэх зорилгоор өвсний нөөцийг бүрдүүлдэг. Харамсалтай нь, олон сүрэг маш үргэмтгий болсон тул өвс тэжээл тараах ажлыг тактикийн үүднээс яаравчлан төлөвлөх хэрэгтэй байдаг. Өдийн болтол тахийн сүргийн дийлэнх нь хар сүүлт зээр, хулангийн адил цаг агаарын эрс тэс уур амьсгалаас сэргийлж аюулгүй бүс рүү нүүлгүй, анх дассан газраа байрлаад байна. Энэ нь тэд устаж үгүй болохоос өмнө эзэмшиж байсан амьдрах орчны талаархи уламжлалт мэдлэг, инстинкт дутмагаас болдог байна. Иймээс тэдний энэ мэдлэг дахин сэргэх ёстой. Иймд бид одоогоор цаг агаар муудахгүй гэж мөн өвс тэжээлийн яаралтай тусламжийн хандивт найдаж байна. Тийм учраас энэ өвөл зудтай байвал өвс тэжээл яаралтай худалдан авах хандив тусламж хэрэгтэй болно. Тусламж хандив бүр нь бидэнд маш чухал бөгөөд эдгээр нэмэлт зардлыг төлөхөд тусалдаг!



Унага ивээн тэтгэх

Ердөө 100,000 төгрөг Та хандивласнаар тахийн унагыг өөрийн амьдрах орчинд удам угсаагаа хадгалан үлдэхэд туслах болно! Тахь нэг бүр чухал.

Түүний нэрийг яаж нэрлэхээ Та өөрөө шийдээрэй.

Зул сарын баяраар тахийн үрчлэл бэлэглэх нь - энэ нь утга учиртай бөгөөд (нэг удаа ч гэсэн) зүйл амьтныг тогтвортой хамгаалахад тусална!

Дэлгэрэнгүйг <https://savethewildhorse.org/donate/> дээрээс уншина уу



Б.Ариунбилэг, Ховд аймаг Булган сум 1-р сургууль

Энэ жилийн 9 дүгээр сард 5 гүү унагласан билээ. Түүний дотор 9 дүгээр сарын 18-нд 23 настай Зур (Келн хотод төрсөн) гүү, 9 дүгээр сарын 29-нд 9 настай Анар гүүнүүд нэлээн хожуу унагласан юм. Хожуу төрсөн унаганууд хорогдох магаддал өндөр байдаг.

Энэ нь Батаа шиг өнчирсэн унаганд ч хамаатай. Гэсэн хэдий ч түүний биеийн байдал сайн байгаа бөгөөд хашаанаас суллахын өмнө өдөр болгон өвс тэжээлээр байгаль хамгаалагчид тэжээж байна.

Хамгаалалтын захиргааны даргын үүрэг гүйцэтгэгч Н.Алтансүх ("Аагий") Батаа унагыг угжаар хооллоож байгаа нь.

2021 онд мэнд орсон 349 тахийн популяциас 2022 онд 70 унага төрж дээд амжилтыг тогтоосон байна.

Энэ өвлийн "Зуд"-ыг өнтэй давахад Тахийн сүрэгт туслахыг хүсье!

USD/CHF 50.- нь 25 бодгаль тахийг өвс тэжээлээр нэг өдрийн турш хангахад хангалттай.

USD/CHF 100.- өвс тэжээлийг шаардлагатай газарт нь тээвэрлэх ажлыг баталгаажуулж өгнө.

Бид ямар ч хэмжээтэй байсан хандивыг талархан хүлээж авах болно!



## Гол хүмүүсийн тухай мэдээлэл

ГИДЦГ-ын "Б" хэсгийн Хамгаалалтын захиргааны дарга Оюунсайханы Ганбаатар 2022 оны 9 дүгээр сарын сүүлчээс ХЗ-ын даргын ажлаа өгч, байгаль хамгаалалын шинэ ажлыг эхлүүлж байгаа. О.Ганбаатар нь 1999 онд буюу тэр үед биологийн ангийн оюутан байхдаа уг төсөлтэй нягт холбоотой байсан Проф. Равчигийн Самъяатай хамтран Тахийг сэргээн нутагшуулах судалгааны хөтөлбөрт анх ажиллаж эхэлсэн билээ. Энэ үед Тахийн судалгааны хөтөлбөр дөнгөж л эхэлж байлаа. Тууштай хөдөлмөрч Оюунсайханы Ганбаатар нь олон жилийн турш асар их туршлага, мэдлэг, мэдээлэл хуримтлуулж, уг төслийн орлошгүй гишүүн, тахийн шилдэг мэргэжилтэн болон төлөвшсөн. Түүний орон нутгийн болон улсын хэмжээн дэхь удирдлага, малчид, байгаль хамгаалагчид болон Олон Улсын тахь групптэй маш сайн хамтран, харилцаа холбоотой ажилласан авъяас чадвар нь сэргээн нутагшуулах хөтөлбөрийг эрс ахиулахад ихээхэн хувь нэмрээ оруулсан. Онцлох үйл явдал бол 2019 онд Дархан цаазат газрын нутгийг өргөтгөн тэлсэн асуудал байлаа. Мөн О.Ганбаатар нь Монголд болон олон улсын хурал зөвлөгөөнүүдэд олон тооны мэдээлэл таниулах ажлыг хийж, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байна. О.Ганбаатар нь шинэ томилогдсон ажлаараа өөр нутагт тахь нутагшуулахад тохиромжтой эсэхийг үнэлэх үнэлгээний ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ мөн эрдмийн ажлаа дуусган хамгаалах болно. Тахь нутагшуулах үйлсэд 23 жил үнэлж баршгүй үр бүтээлтэй ажилласан

О.Ганбаатартаа Олон Улсын тахь группийн хамт олон чин сэтгэлээсээ талархаж байна. Түүний болон түүний гэр бүлийнхэнд цаашдын ажилд нь өндөр амжилт хүсье!

О.Ганбаатарыг үүрэгт ажлаа өгсөнтэй холбоотой ГИДЦГ-ын "Б" хэсгийн ХЗ-ны даргын хариуцлагатай ажлыг Н. Алтансүх ("Аагий") түр хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд тэрээр ДЦГ-ын зүүн хойд хилийн Бижээс гаралтай, МУИС-ийн Эдийн засгийн факультетын Эдийн засгийн бакалавр, Ховд их сургуулийн шинжлэх ухааны магистр зэрэгтэй. 2007 оноос хойш ДЦГ-ын ХЗ-ны мэргэжилтэн, дараа нь ахлах мэргэжилтнээр ажиллаж байсан тул тэрээр орон нутгийн нөхцөл байдал, оролцогч талуудыг сайн мэддэг. Н.Алтансүхэдээ шинэ албан тушаалд нь баяр хүргэж, үр бүтээлтэй хамтран ажиллахыг хүсэн ерөөе.

Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэтэй Олон Улсын тахь групп нь ГИДЦГ-ын "Б" хэсгийн менежментэд хамтран ажиллах Санамж бичиг дээр 2022 онд гарын үсэг зурж цаашдаа хамтран ажиллах боллоо. Бид БОАЖЯамтай цаашид ч үр дүнтэй хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

*Байгаль орчин, аялал жуулчлалын шинэ Сайд Б.Бат-Эрдэнэ, Олон улсын тахь группын Ерөнхийлөгч доктор Райнхард Шнидриг, Монгол дахь Олон улсын тахь группын захирал Жамъяндоржийн Батсүх, БОАЖЯ, Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын мэргэжилтэн Т.Болдбаатар (баруун талаас 1) болон Ш. Цэрэндулам нар (баруун талаас 2-т).*



О.Ганбаатар



Н.Алтансүх



Зургийг: Х.Сэргэлэнбат

Тахийг сэргээн нутагшуулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй ажилласан, ХЗ-ны дарга асан О.Ганбаатар; Онцлох үйл явдал бол 2019 онд Дархан цаазат газрын нутгийг өргөтгөн тэлсэн асуудал байв.

## Бид байгаль хамгаалагчид



"Ямар ч бяцхан хүү цохыг няцалж чадна, гэхдээ дэлхийн бүх профессорууд цохыг дахин амилуулж чадахгүй." Германы гүн ухаантан Артур Шопенхауэрын (1788-1860) хэлсэн үг бүх хөгжлийн хувьсалын дэвшлийг үл харгалзан 200 жилийн дараа ч үнэн хэвээр байна. Монголын бага, дунд сургуулийн 400 орчим сурагчид "Бид эх дэлхийн найзууд" долоо хоног үргэлжилсэн залуу судлаачдын хөтөлбөрийн үеэр жижигхэн амьтад хүртэл ямар гайхамшигтай байдгийг олж мэдлээ. Олон Улсын тахь групп болон ДЦГ-ын ХЗ-аас 2022 оны 3-р сарын эхээр энэхүү үйл ажиллагааг ГИДЦГ-ын "Б" хэсгийн Орчны бүсийн сургуулиудад зохион байгуулсан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийг ямар зорилгоор байгуулдаг вэ? Тэдний үнэ цэнэ юу вэ? Монголын уугуул амьтан болох тахь хэрхэн эх орондоо эргэн ирсэн бэ? Түүнийг хамгаалснаар бид юунд хүрэх вэ? Энэ сэдвээр илтгэл, мэдээллийн зурагт хуудас, улсын хэмжээнд зохион байгуулсан гар зургийн уралдаан, жүжгийн уралдаан зэргийг зохион байгуулсан нь залуучуудын дунд эдгээр сэдвүүдийн талаар сонирхлыг өрнүүлж байв.

Тахь сэргээн нутагшуулсаны 30 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй бусад арга хэмжээ нь ДЦГ-ын ойр орчмын айл өрхүүдэд үр өгөөжтэй байх, байгаль хамгаалах үзэл санааг өнөөгийн болон ирээдүйн нийгэмд нэвтрүүлэх зорилготой юм. Иргэдэд үйлчлэх үүднээс Биж, Алтансоёмбо баг (Говь-Алтай аймаг) дахь бага сургуулийн хичээлийн танхимыг шинэчилэн тохижуулсан байна. ДЦГ-ын Орчны бүсэд амьдардаг

*Жүжгийн тэмцээнд шалгарсан 20 сурагч 6 дугаар сард тусгай хамгаалалттай газар нутагт очиж үзэв.*

*Уралдаанд шалгарсан 100 орчим сурагчид 9 дүгээр сард "БИД БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИД" уриан дор аялал зугаалгаар явсан. Ахлах ангийн сурагчид нь энгийн судалгааны багаж хэрэгслийг ашиглан голын усны чанарыг үнэлэх, ургамал, сээр нуруугүй амьтад, тэдгээрийн экосистемийг судлах, хими, биологийн чиглэлээр суралцсан бол бага ангийн сурагчид нь амьтны мөртэй танилцаж, тахь, усны амьдрал, хэвлээр явагчидад ажиглалт хийсэн байна. Зураг: ©*

300 өрх, оюутан сурагчид болон байгаль орчны чиглэлээр суралцаж буй оюутнуудад экосистемийн тухай гайхалтай гэрэл зураг, мэдээлэл бүхий хуанли гардуулж, 30 жилийн түүхийг өгүүлсэн Тахийн Мэдээ сонин 1000 ширхэгийг тараасан байна.

Том зүйл багаас эхэлдэг. Хэн мэдэх вэ? – "Залуу судлаач" хөтөлбөрт оролцсон сурагчдын дотор ирээдүйн агуу судлаач байгаа ч юм билүү? Бид байгалийн өв сангаа хадгалан хамгаалж чадсанаар ядаж л хэн нэгэн цох хорхойг дахин амилуулах гэж оролдох шаардлагагүй болно!

2022 онд "Залуу судлаачид" хөтөлбөрийг ГИДЦГ-ын "Б" хэсгийн Орчны бүсийн сургуулиудад зохион байгуулсан.



*Залуу судлаачид хөтөлбөрийн хүрээнд ДЦГ-ын ХЗ болон ОУТГ-ын биологич Г.Ёндонгийн удирдлаган дор судалгаанууд хийсний нэг нь Хонь ус, Тахь ус баян бүрдүүдийн экологийн чадавхийн талаар иж бүрэн мэдээлэл цуглуулах ажлыг хийжээ.*

**Тахийн их өлгий нутагт Таныг сонирхолтой, адал явдалт аялал хүлээж байна.**

ГИДЦГ-ын “Б” хэсгийн зэрлэг адууг байгаль дээр нь үзэж, шим мандлын нөөц газрын нүүдэлчин малчин айл өрхүүдийн өдөр тутмын амьдралтай шимтэн танилцаарай.

Огноо: 2023 оны 7/8 сар

Odkha Travel болон Lena Michler нарын аялал жуулчлалын мэргэжилтнүүдийн удирдлаган доор Дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.odkha-travel.de/touren/themenundspezialreisen/>



## Тахь сэргээн нутагшуулсаны 30 жилийн ой

Монгол дахь Олон Улсын тахь групп, ГИДЦГ-ын “Б” хэсэг, Хустайн нурууны Байгалийн цогцолборт газар болон Хомын талын Байгалийн цогцолборт газар зэрэг хамтран Монгол Улсад Тахь сэргээн нутагшуулсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд эрдэм шинжилгээний хурал, хэвлэлийн бага хурал, ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, гар зургийн уралдаан болон үзэсгэлэн зэргийг зохион байгуулав.

### ДЦГ-ын орчны бүс дахь гэрийн адуу

Дархан цаазад газрын нутагт чөлөөтэй идээшилж буй гэрийн адуу олширч байна. Тиймээс 2022 оны 9-р сарын дунд үеэс байгаль хамгаалагчид тэдгээр адууны тоо, байршлыг тогтооход - нийт 5 байршилд 20 хэсэг 271 тооны гэрийн адуу байсан байна. Энэ нь тахь гэрийн адуутай эрлийзжих эрсдэл бий болж байгаагийн үзүүлэлт юм. Цаашид эдгээр тоо баримтыг тахийн тархацын мэдээлэлтэй харьцуулан дүгнэлт хийх болно. Хромосомын тоо нь өөр өөр байдаг хэдий ч зэрлэг адуу болон гэрийн адуу үржих чадвар бүхий төл төрүүлэх боломжтой. Тиймээс тэдний эрлийзжих эрсдэл өндөр байна.



Б.Билгүүнтөгөлдөр, Говь-Алтай аймаг Тайшир ахлах сургууль

Бид Тахь сэргээн нутагшуулсаны 30 жилийн ойн хүрээнд олон төрлийн арга хэмжээг зохион байгуулснаар ДЦГ-ын орчны бүсийн айл өрхүүдэд үр өгөөжөө өгөхийг эрмэлзэж байна.

## Хамтдаа үнэ цэнийг бий болгоно



Зургийг: Саруул Fischer

Монголын малчдын хувьд орлогын гол эх үүсвэр нь ноос ноолуур байдаг. Байгалийн энэхүү үнэт бүтээгдэхүүний олон улсын эрэлт хэрэгцээ, амьжиргааны өртөг нь сүүлийн жилүүдэд бог малын тоо толгойг (ялангуяа ямааны) огцом өсөхөд хүргэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлттэй нийлээд бэлчээр хэт их ашиглагдаж бэлчээргүй болох гэсэн болгоомжлолыг төрүүлж байна. Гэсэн хэдий ч Монголын нийт хүн амын 1/3 орчим нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг ба энэхүү нүүдэл шилжилт нь тогтвортой амьдралын хэв маягийн үндэс байж болох юм.

ДЦГ-ын Орчны бүсэд амьдардаг малчдын өрхүүд нүүдэлчний соёлын өв болон амьдралын уламжлалт ахуйгаа хадгалах зорилгоор 2022 оны 10 дугаар сард “Хөвчийн цагаан сорт” хэмээх хоршоог байгуулахыг Биж болон Перм багийн (хоёулаа ДЦГ-ын орчны бүсэд байрладаг) нийт 110 малчид санал нэгтэй зөвшөөрч хоршооны удирдах зөвлөл болон хяналтын багийн хамт 15 гишүүнтэй байгуулагдав. Шинэ гишүүд хэзээ ч нэгдэх боломжтой. Тус хоршоо нь мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах бөгөөд ДЦГ, ОУТГ болон Тогтвортой ноолуурын холбоо ТНХ (тогтвортой ноолуурын үйлдвэрлэлийн байгууллага)-той хамтран ажиллах юм. ТНХ нь малчдад бэлчээрийн менежмент, хамгаалалтын бүсэд мал аж ахуй эрхэлсэнээр хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэхэд зөвлөгөө өгч, ноолуурын зах зээлд гол анхаарлаа хандуулан ажиллах болно.

Энэ зорилгоор 2023 онд ТНХ-оос сургалтуулыг зохион байгуулна.

Эхний жилдээ ГИДЦГ-ын “Б” хэсгийн ХЗ нь техникийн багийн хамт эдгээр үйл ажиллагааг дэмжин ажиллах бөгөөд хоршооны дараагийн хуралдааныг 2023 оны 2-3 дугаар саруудад зохион байгуулах болно.



Г.Баасанхүү, Хөвсгөл аймаг Тосонцэнгэл ахлах сургууль

Шинэ хоршоо нь малчдад бэлчээрийн менежмент, ажлынхаа ашиг орлогыг хэрхэн оновчтой болгох талаар зөвлөх болно.



## Гантай үеийн бэлчээрийн ашиглалт

Зүүнгарын говийн үржил шимгүй бэлчээрийг маш болгоомжтой ашиглах ёстой бөгөөд ингэснээр ургамлын бүрхүүл сэргэх болно. Үүнийг нүүдэлчин малчид мэдэж байгаа нь ойлгомжтой. Гэхдээ тэд сүргийн өсөлт, тусгай хамгаалалттай газар нутагт байгаа зэрлэг туурайтан амьтдын популяци болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг харгалзан үзэхэд суралцах ёстой. Үүнд шаардагдах тоо баримт ГИДЦГ-ын "Б" хэсгийн нүүдэлчин малчдын нүүдлийн хөдөлгөөнийг бэлчээрийн ашиг шим, хөрсөнд суурилсан ургамлын шинжилгээтэй холбосон 20 сарын эрдэм шинжилгээний судалгаанд шаардлагатай<sup>1</sup>.

Мэдээ дамжуулагч хүзүүвч зүүсэн гэрийн 19 ямаанаас авсан мэдээллээр малчид малтайгаа шим тэжээлээр баялаг Хялгана өвстэй бэлчээрт буудаллахыг илүүд үздэг байна. Малчид жилд 9 удаа (3-5 долоо хоног тутамд) бэлчээрээ сэлгэн, буудалласан газраасаа 5 км хүртэл нүүдэг, өвөлжөө болон зуслан нь хоорондоо 70-120 км-ийн зайд байрладаг байна. Зүүнгарын говьд нутгийн малчдын нүүдэллэх хөдөлгөөн их байгаа нь ургамлын нөмрөгийг харьцангуй тогтвортой ашиглахад нөлөөлж байна.

2022 оны 9-р сараас хойш зарим гэрээсээ хол бэлчэж буй үхэр, эзэнгүй нохойнд мөн дамжуулагч хүзүүвч зүүсэн байна. ДЦГ-т нутагладаг малчин өрхүүд голчлон ямаа, хонь малладаг ч зарим малчид үнээтэй байхыг илүүд үздэг. Малчин өрхүүд ДЦГ-ын баруун хойд хэсэгт орших Чонж хэмээх газрыг голчлон ашигладаг бол тэндхийн ургамал нь бог мал сүргийг бодвол үхэрт илүү шингэцтэй байдаг. Мал сүргийн хөдөлгөөний хэв маягийг ойлгохын тулд мөн зарим хоточ ноходод мэдээ дамжуулагч хүзүүвч зүүсэн бөгөөд энэ ажилд тусалсан байгаль хамгаалагчид болон мал сүргийн хөдөлгөөнийг хянах боломжийг олгосон малчдад талархалаа илэрхийлье.



Зургийг: Д.Буянтогтох



Зургийг: Д.Буянтогтох

Тусгай хамгаалалттай газар нутагт амьдарч буй иргэд байгалийн нөөцийг байгаль орчинд ээлтэй ашиглахын тулд тодорхой дүрэм, журмыг дагаж мөрдөх ёстой. ГИДЦГ-ын "Б" хэсгийн байгаль хамгаалагчид хэдэн жилийн турш хамгаалалтын бүсэд өвөлжиж буй айл өрхүүдтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Орон нутгийн малчдад ДЦГ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгснөөр, зохицуулалтыг тодорхой болгох боломжтой болсон. ДЦГ-ын ХЗ нь тухайн бүс нутагт хэн орж нутаглаж байгааг мэдэж байдаг бөгөөд ингэснээр тэд байгаль орчноо хамгаалахын зэрэгцээ малчдын хэрэгцээг хангах боломжтой.

*Mitchler L. et al, Moving Toward the Greener Side: Environmental Aspects Guiding Pastoral Mobility and Impacting Vegetation in the Dzungarian Gobi, Mongolia. Rangeland Ecology and Management, Volume 83, July 2022, 149-160*



М.Намуунзул, Улаанбаатар ахлах сургууль



Б.Амина, Булган аймаг 1-р сургууль

Нүүдэлчдийн ДЦГ-ын бэлчээрийг ашиглах нь гантай үед онцгой хүндрэл учруулдаг бөгөөд хамтран цуглуулсан мэдээлэл нь үүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй болгоход туслах болно.

## Говийн их дархан цаазат газрыг Дэлхийн Өвд бүртгэх болов уу?



Бидний хувьд асуудал байхгүй! Онгон зэрлэг, хүйтэн тал хээр нутгийг өөр хаанаас олж болох вэ? Олонхи тал хээр нутгуудыг дэлхий даяар өөрчлөн ашиглаж байна. Хойд Америкийн тал хээр нутгийн багахан үлдсэн хэсгийг эс тооцвол үндсэндээ алдагдаж, Евразийн хээрийн бүсийг газар тариаланд эрчимтэй ашиглаж байна. "Их говь" буюу "А" болон "Б" хэсэг бүхий Монгол орны асар том шим мандлын нөөц газар нь одоо Төв Азийн тал хээр, цөлийн дэлхий

дахинд хосгүй амьдрах орчныг, тухайлбал "Их говийн 6 гайхамшиг" гэж нэрлэдэг Хавтгай хэмээх зэрлэг тэмээ, Бөхөн, Хар сүүлт зээр, Мазаалай (Говийн баавгай), Хулан (Азийн хулан), мэдээж Тахь (Зэрлэг адууны удам) зэргийг хамгаалж байна. Монгол улс энэхүү шим мандлын нөөц газрыг Дэлхийн өвд бүртгүүлэх хүсэлтээ гаргаж байна. Энэ нь түүний экологийн ач холбогдлоор хэмжигдэх болно.

## Тахийг хамгаалах үндэсний дэд хөтөлбөр



Монгол Улсад тахь сэргээн нутагшуулах эхний алхмууд 30-аад жилийн өмнө хувь хүн санаачлагчдын сонгон шалгаруулсан хоёр өөр газар (ГИДЦГ-ын "Б" хэсэг, Хустайн нуруу)-т бараг нэгэн зэрэг эхэлсэн байдаг. 12 жилийн дараа гурав дахь газар (Хомын тал)-т мөн л хувь хүний хөрөнгө оруулалттайгаар хийгдэж, 2 жилийн өмнө газар нутгийг нь өргөтгөн (урьд Хустайн нурууны ижил) Байгалийн цогцолборт газрын ангилалд хамруулсан билээ.

Тахийг хэд хэдэн нөөц газруудад зэрэг нутагшуулж байгаа нь Монгол орны тахийн популяцийг тухайн газар бүрт байж болох аюул заналд дасан зохицоход илүү тэсвэртэй болгож байна. Эдгээр нөөц газруудын гурван байгууллагын хамтын ажиллагаа нь тухайн төрөл зүйлийг хамгаалах нэгдмэл, зохицуулалттай стратеги, олон төрлийн хамтын ажиллагааг бий болгох боломжийг олгож байна. Саяхан гурван нөөц газар хамтран 2020-2025 оны Хамтын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, БОАЖЯ-д батлуулахаар ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд Монгол дахь ОУТГ-ын баг тахь сэргээн нутагшуулах нийтлэг аргачлалыг боловсруулах ажлыг хариуцан хийж байгаа. Мөн Тахь судлалын үндэсний төв болон Хамтарсан эрдмийн зөвлөлийг байгуулснаар Тахь судлалын олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилготой юм.

ГИДЦГ-ын "Б" хэсгийн баруун хэсэгт орших Тахь ус баянбүрдэд Хулан, Хар сүүлт зээр болон Тахийн бөөгнөрсөн холимог сүрэг үүссэн байна.

Зургийг: Сүхбаатарын Далайцэрэн



Н.Авдрахман, Ховд аймаг Булган сум 1-р сүхгууль

Гурван нөөц газрын хамтын ажиллагаа нь тахийг хамгаалах нэгдсэн, уялдаатай стратеги хэрэгжүүлэх боломжийг олгох болно.

## Зүйлийн дүр төрх: Говийн том бор сарьсан багваахай<sup>1,2</sup>



Зургийг: 2007 V.Rossina

Товчхондоо: Говийн том бор сарьсан багваахай (*Eptesicus gobiensis*)-г анх 1926 онд шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлсон ч төдийлөн сайн мэддэггүй байсан байдал нь түүний баримтат хуудсыг төгс болгоход хангалтгүй байсан нь мэдээж хэрэг.

Говийн том бор сарьсан багваахайтай холбоотой баримтууд ховортой адил Та түүний ангилал зүйтэй мөн адил амархан будилж болно. Сарьсан багваахайн багт, *Vespertilionidae* овог (үдшийн сарьсан багваахай), *Vespertilioninae* (4 дэд овгийн нэг), *Eptesicini* овог (9 овгийн нэг), *Eptesicus* (нийт 63 зүйлтэй 11 овгийн нэг) багтдаг байна.

Үдшийн сарьсан багваахай нь *Muridae* (хулгана) ба *Cricetidae* (үлийн цагаан оготно, шишүүхэй, шинэ ертөнцийн хулгана гэх мэт) мэргчдийн овгийн дараа ордог хамгийн өвөрмөц хөхтөн амьтдын овог бөгөөд 1400 орчим зүйлтэй сарьсан багваахайн багийн хамгийн том нь юм.

Одоогийн байдлаар – Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) ангиллын дагуу 54 төрлийн *Vespertilionidae*-ийн 496 зүйлийн 6 зүйл нь маш ховордсон, 15 зүйл ховордсон, 27 зүйл нь эмзэг байдалтай гэж үнэлсэн.

Энэ будилаантай тоо нь юу гэсэн үг вэ? Энэ нь сарьсан багваахайнууд асар олон янз байдгийг харуулж байгаа юм. Тэд идэвхтэй нислэгийг эзэмшсэн цорын ганц хөхтөн амьтад тул энэ нь шувуудын гэгээтэй үед эзэмшдэг тоо томшгүй олон экологийн байршлыг эзэмшсэн нь гайхах зүйл биш юм. *Eptesicus gobiensis* нь 900 орчим зүйлийн нэг бөгөөд ихэвчлэн шавьжин идэштэй жижиг сарьсан багваахай юм. Тэдний зарим нь шавьжин идэшнээс гарч, өөрийн жингийн 60 хувь

хүртэл жинтэй тэнцэх мэлхий, загас, шувуу эсвэл бүр жижиг мэрэгч амьтдыг агнадаг, эсвэл амьтадын цусыг сорч хооллодог. Харин 9 омог бүхий 8 дэд овгийг бүрдүүлдэг жимсээр хооллодог Old World flying fox нь огт өөр шинж тэмдэгтэй юм.

Сарьсан багваахайн асар олон янз байдал нь тэдний экологийн чухал ач холбогдолтой нийцэж байдаг. Үүнд тэдгээрийн бордоо нийлүүлэгч, цэцэгт тоос хүртээгч эсвэл жимсний үрийг тараагч шавьжны популяцийг хянах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэхээс гадна, түүнгүйгээр халуун орны зарим модны төрөл зүйл популяция шинэчлэх боломжгүй байдаг. Ихэнх сарьсан багваахайнууд бүлгээрээ амьдарч, агнадаг тул амьдрах орчинг нь түйвээх, амьдрах орчин, үүрлэх газраа алдах зэрэгт онцгой өртөмтгий байдаг. Тэдний аймшигтай дүр төрх нь маш их зүйлээр баялаг, экологийн хувьд зайлшгүй шаардлагатай энэхүү хөхтөн амьтдын бүлэгт дарамт учруулж байна. Коронагийн цар тахал нь үүнийг улам даамжруулж, сарьсан багваахайн колониудыг бүхэлд нь харгислан устгахад хүргэсэн. Бид сарьсан багваахайнуудыг барихын тулд амьдрах орчин руу нь дайрч, өөрсдийгөө аюултай вируст өртүүлсэн нь сарьсан багваахайнуудын буруу биш юм!

### Баримтат хуудас: Говийн том бор сарьсан багваахай

*Eptesicus* төрөлд хамаарах жижиг зүйл. Биеийн урт 5.7-6.5 см, жин 9-15 гр. Нурууны үслэг нь шаргал хүрнээс хар саарал, хэвлий нь хүрэн саарал өнгөтэй. Нүүр, чих, далавчны мембран хар хүрэн өнгөтэй. Чих нь нилээд богино, дугуй хэлбэртэй. Эм нь 2 хөхтэй.

Төв Азийн ихэнх хэсэгт амьдардаг боловч хаана ч хамгийн ховор тохиолддог сарьсан багваахайн зүйлийн нэг юм. Далайн түвшнээс дээш 200-аас 3300 метрийн өндөрт цөл, хагас цөл, хээрийн амьдрах орчинд, ихэвчлэн уулархаг газар нутагладаг. Заримдаа суурин газруудад ч байдаг. Усны цооног, модтой, хад чулуутай голын хөндийг илүү эрхэмлэдэг.

Ихэнхдээ ганцаар эсвэл жижиг бүлгүүдээр амьдардаг. Өдрийн цагаар хонгил, хадны ан цав, заримдаа агуйн үүдэнд нуугдана. Шөнийн амьдралтай, нар жаргасны дараахан идэвхжил нь оргилдоо хүрдэг. Харьцангуй хүчтэй эрүү, шүд нь эрвээхэй, цох (газрын гүнээс) гэх мэт шавьжийг агнах боломжийг олгодог. Ичдэг.

Намар ороо нь орж, зургаан сард төрдөг. Нөхөн үржихүйн түвшин бага, ихэвчлэн нэг зулзагатай, удаан өсөлттэй.

Өргөн тархсан учраас одоогоор аюулд өртөөгүй ("анхааралд өртөхөөргүй") гэж тооцогддог. Одоогийн байдлаар популяцид заналхийлж буй тодорхой эрсдэл байхгүй ч мэдээлэл ховор байна. Ган гачигаас болж шавьжны популяци багасах нь түүнд асуудал болж магадгүй юм.

<sup>1</sup> Wilson D.E. & Mittermeier R.A. eds, 2019, *Handbook of the Mammals of the World, Vol. 9. Bats*. Lynx Edicions, Barcelona

<sup>2</sup> Batsaikhan N. et al, *A Field Guide to the Mammals of Mongolia, 2014*, Zoological Society of London, London

## Зэрлэг адууны ирээдүйг хамтдаа баталгаажуулцгаая



"Говийн Их дархан цаазат газрын "Б" хэсэг нь дахин давтагдашгүй өвөрмөц газар билээ. Юу нь илүү гайхалтай болохыг хэлэхэд хэцүү: түүний уулс, толгод, өргөн уудам тал, баянбүрдүүд эсвэл тэнд байгаа зүйрлэшгүй ургамал, амьтны төрөл зүйл. Гэвч нэг зүйл бидэнд тодорхой байна: байгалийн өвийг өвлүүлэн үлдээхийн тулд бид Говийн Их дархан цаазат газрын "А" болон "Б" хэсгийг хоёуланг нь хадгалан хамгаалах ёстой!"

О.Хүрэлбаатар, ГИДЦГ-ын "Б" хэсгийн ХЗ-ны Аялал жуулчлал, сургалт сурталчилгаа, хамтын ажиллагаа болон Орчны бүсийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

### Таны хандив бидэнд хэрхэн тусалдаг вэ?

#### 150,000 ТӨГРӨГ

Та онцгой байдлын үед 25 тахийн нэг өдрийн өвс тэжээлийг санхүүжүүлнэ.

#### 225,000 ТӨГРӨГ

Та ДЦГ дахь нүүдлийн шувуудын амьдрах, үржих чухал чухал бүс газруудыг тодорхойлж, хадгалан хамгаалахад (дэлхийд нэн ховордсон 22 зүйл шувууд орно) туслах болно.

#### 300,000 ТӨГРӨГ

Та 25 тахийн нэг өдрийн өвс тэжээлийг тээвэрлэлтийн хамт санхүүжүүлнэ.

#### 600,000 ТӨГРӨГ

Та Хамгаалалтын захиргааны байрны уулзалт болон зочдын өрөөний цонхыг санхүүжүүлэх болно.



Таны өгсөн хандив бүр Говийн өвөрмөц зэрлэг амьтдын төрөл зүйл, Төв Азийн тал хээрийн ургамал, амьтны аймгийг хадгалахад хувь нэмрээ оруулна.

Э.Тамир, Төв аймаг, Аргалант ахлах сургууль

Биднийг Facebook Instagram дээрээс дагаарай  

Та "Тахийн найз нөхөд" болох уу?

- Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж 130,000 төгрөг
- Оюутан, залууст зориулсан "Унага" гишүүний хураамж 50,000 төгрөг

Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь товчоо

ХХБ 499114883 ам. долл.

499248691 төгрөг



Эрхлэн гаргасан  
Freunde des Wildpferdes  
c/o Stiftung Wildnispark Zürich  
Alte Sihltalstrasse 38  
CH-8135 Sihlwald / ZH  
www.savethewildhorse.org  
info@savethewildhorse.org  
itg.ulaanbaatar@gmail.com